



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

Аудитын код: ДГА-2020/67/СТА-ТШЗ

Цахим хуудас: www.audit.mn

Дорноговь аймаг
2020 он

**Дорноговь аймаг дахь Төрийн аудитын газрын захирал
бөгөөд тэргүүлэх аудитор Ч.Ариунаа**

Утас: 99092469 Цахим хаяг: ariunaach@audit.gov.mn

Аудитын менежер: Э.Энхцэцэг

Утас: 90077079 Цахим хаяг: enkhtsetsege@audit.gov.mn

Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Уваа уул” аудит ХХК

Утас: 99108763 Цахим хаяг: uwaauul.audit@gmail.com

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

Агуулга

1. Аудитын гэрчилгээ	2
2. Аудитын тайлан.....	4
2.1. Оршил	4
2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага	4
2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт	4
2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин	5
2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ	5
2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал	6
2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар	6
2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд	6
2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга.....	7
2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн.....	7
2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал	7
2.12. Шилэн дансны мэдээлэл	7
2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт	7
2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл.....	8
3. Менежментийн захидал	9
4. Аудит хийсэн санхүүгийн тайлан.....	11
4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	11
4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан.....	12
4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	14
4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан.....	16
4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан.....	17
5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт	20

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
АОУС	Аудитын Олон Улсын Стандарт

1. Аудитын гэрчилгээ


**ДОРНОГОВЬ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
44103 Дорноговь аймаг, Сайншанд сум,
3 дугаар баг, Орон нутгийн өмчийн III байр,
Утас: (705) 2-27-34
Вэб сайт: dornogovi@audit.gov.mn

ДОРНОГОВЬ АЙМГИЙН САЙНШАНД
СУМЫН ЕРӨНХИЙ БОЛОВСРОЛЫН 5
ДУГААР СУРГУУЛИЙН ЗАХИРАЛ
Б.ЭРДЭНЭЦЭЦЭГ ТАНАА

2020.02.28 № 1-6/222
танай _____ -ны № _____ -т

Аудитын гэрчилгээ

Монгол Улсын Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болсон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд санхүүгийн тайлангийн аудит хийв.

Зөрчилгүй санал дүгнэлт

Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээ болон төсвийн гүйцэтгэлийн тайланг материаллаг зүйлсийн хувьд Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, УСНББОУС-д нийцүүлж, Сангийн сайдын баталсан бодлого, журам, зааврын дагуу үнэн, бодитой, шударга илэрхийлсэн тул зөрчилгүй санал дүгнэлт гаргаж байна.

Санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартад нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Санхүүгийн тайлангийн аудитын журам, зааврын дагуу гүйцэтгэсэн. Эдгээр нь санхүүгийн тайлан материаллаг буруу илэрхийллээс ангид эсэх талаар үндэслэлтэй баталгаа олж авах зорилгоор аудитыг төлөвлөж, гүйцэтгэхийг шаарддаг.

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын Ерөнхий боловсролын 5 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайлан дахь үлдэгдэл, ажил гүйлгээний дүн хэмжээ болон илчлэл тодруулга, тус байгууллагын хэмжээнд мөрдөж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, бүртгэл хөтлөлт, программ хангамж, дотоод хяналтын систем болон удирдлагын хийсэн томоохон тооцооллыг шалгаж, аудитын санал дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг хангалттай цуглуулсан.


Бидний хийсэн аудит тус санхүүгийн тайлан, тодруулгад санал дүгнэлт өгөх хангалттай, зохистой үндэслэлийг бүрдүүлсэн бөгөөд аудитын дүнд үндэслэсэн санал, зөвлөмжийг аудитын тайланд тусгасан болно.

Үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч нь Төсвийн тухай хуулийн 26 дугаар зүйлийн 26.1-д заасны дагуу тайлант хугацааны санхүүгийн тайлан, тодруулгыг Нягтлан бодох бүртгэлийн болон Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандарт, түүнтэй нийцүүлэн Сангийн сайдын баталсан журам, зааврын дагуу бэлтгэж, тайлагнах үүрэгтэй.

Аудитын дээд байгууллагуудын нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчим, стандарт болон Аудитын олон улсын стандартын дагуу аудит хийж, жилийн эцсийн төсвийн гүйцэтгэл, санхүүгийн тайланд санал дүгнэлт өгөх нь төрийн аудитын байгууллага үүрэг юм.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ч.АРИУНАА

2. Аудитын тайлан

2.1. Оршил

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын дүн, дүгнэлтийг Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн *ᠴᠠᠪᠡᠳᠠᠭ* Б.Эрдэнэцэцэг Танд танилцуулж байна.

Энэхүү тайланд үйлчлүүлэгчийн санхүү, нягтлан бодох бүртгэл, дотоод хяналтын системд хийсэн үнэлгээний тойм, аудитын явцад илрүүлсэн гол зүйлс, гаргасан шийдлүүд, анхаарал хандуулахуйц асуудал, залруулаагүй материаллаг болон материаллаг бус алдаа зөрчил, тодруулга зэрэг аудитын үр дүн, аудитын дүгнэлтийн хэлбэр, түүний үндэслэлийн талаар тус тус хураангуйлан тэмдэглэв.

Аудитын дүнд үндэслэсэн үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэл, элэгдэл дууссан ашиглагдаж байгаа үндсэн хөрөнгийг дахин үнэлэх, өглөг, авлагын тооцоог барагдуулах, тооцоо нийлж ажиллах зөвлөмжүүдийг Менежментийн захидалд тусгасан болно.

2.2. Аудит хийх үндэслэл, зорилго, талуудын хүлээх үүрэг, хариуцлага

Бид Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2, 18 дугаар зүйлийн 18.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусвар болгосон санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн гаргасан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, заавар, журмын дагуу үнэн зөв, шударга илэрхийлэгдсэн эсэхэд дүгнэлт өгөх нь энэхүү аудитын зорилт байв.

Төсвийн шууд захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайлангаа Төсвийн тухай хууль болон УСНББОУС, түүнд нийцүүлэн баталсан төсвийн байгууллагын нягтлан бодох бүртгэлийн бодлого, журмын дагуу үнэн зөв, бодитой бэлтгэх үүрэгтэй.

Харин тухайн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг дээрх хууль болон бодлого, журмын дагуу материаллаг алдаагүй, үнэн зөв, шударга илэрхийлсэн эсэхэд дүгнэлт өгөх нь Төрийн аудитын байгууллагын үүрэг юм.

Аудитыг 2020 оны 1 дүгээр сарын 25-наас 2020 оны 2 дугаар сарын 23-ний хооронд гүйцэтгэж, аудитын тайланг 2020 оны 2 дугаар сарын 25-ны өдөр эцэслэн баталгаажуулж, Төсвийн шууд захирагчид хүргүүлэхээр төлөвлөн, Дорноговь аймаг дахь төрийн аудитын газрын захиалгаар “Уваа уул аудит” ХХК-ийн захирал Ч.Мөнхтуяа, чанарын хяналтын менежер А.Оюун, аудитор Р.Пүрэвсүрэн, туслах аудитор Э.Номинчулуун нар хариуцаж хэрэгжүүлэв.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланг “Уваа Уул аудит” ХХК-д 2020 оны 1 дүгээр сарын 25-ны өдрийн 3 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

2.3. Аудитад мөрдсөн бодлого, журам, арга зүй, шалгуур үзүүлэлт

АДБОУС, АОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн бусад зарчимд тулгуурласан Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан Төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайланд аудит хийх журам, төрийн аудитын байгууллагаас санхүүгийн тайлангийн аудитад баримтлах ерөнхий чиглэл, арга зүйг мөрдөн ажиллав.

Дээрх стандарт, зарчим, журамд нийцүүлж аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, холбогдох ажлын баримт материалаар баталгаажуулсан болно.

2.4. Байгууллагын зорилго, үйл ажиллагаа, хууль, эрх зүйн орчин

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн үйл ажиллагааны эрхэм зорилго нь “Хүүхэд бүрийн оролцоог дэмжин сурагчдын суурь чадварыг хөгжүүлж, оюуны хурдыг ахиулахад”-д оршино.

Бүрэн дунд боловсролын үйл ажиллагааны чиглэлийг “Бага, дунд боловсролын тухай” хуулийн 6 дугаар зүйлд дараах байдлаар тодорхойлжээ. Үүнд:

- Эх хэлээрээ утга төгөлдөр найруулж бичих, ярих чадвар, гадаад хэлний зохих мэдлэг эзэмшүүлэх;
- Байгаль, нийгэм, хүмүүнлэг, математик, мэдээлэл зүйн шинжлэх ухааны үндсийг эзэмшүүлэх;
- Мэргэжлийн чиг баримжаа олгож, бие даан амьдарч, хөдөлмөрлөх, үргэлжлүүлэн суралцахад бэлтгэх;
- Бие бялдраа хөгжүүлж, эрүүл аж төрөх ёсыг сахих, гэр бүлийн болон амьдрал ахуйгаа хөтлөх, хүчирхийллээс урьдчилан сэргийлэх, өөрийгөө хамгаалах арга барилд сургах, эх оронч, хууль ёсыг дээдлэх үзэл төлөвшүүлэх.

Тайлант хугацаанд байгууллагын санхүүгийн үйл ажиллагаанд мөрддөг хууль, тогтоомж, бодлого, журамд дараах өөрчлөлт орсон байна. Үүнд:

- Монгол Улсын Их Хурлын 2018 оны 80 дугаар тогтоолоор “Монгол Улсын 2019 оны төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах зарим арга хэмжээний тухай”
- Монгол Улсын Сангийн сайдын 2018 оны 301 дүгээр тушаал “Зардлын хэмжээг шинэчлэн тогтоох тухай”
- Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоол “Журам шинэчлэн батлах тухай”
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-06-10-ны 11/09 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай
- Дорноговь аймгийн ИТХТогтоол 2019-12-04-ны 12/07 төсөвт нэмэлт өөрчлөлт оруулах тухай

2.5. Нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа болон дотоод хяналттай холбоотой хүчин зүйлсийн үнэлгээ

Бид санхүүгийн тайланд материаллаг алдаа байхгүй гэдгийг нягтлах үүднээс үйлчлүүлэгчийн нягтлан бодох бүртгэлийн бодлого, санхүүгийн үйл ажиллагаа, дотоод хяналтыг шаардлагатай гэж үзсэн хэмжээгээр дахин хянасан болно.

Тус сургуулийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь Сангийн яамнаас хэрэгжүүлж байгаа нягтлан бодох бүртгэлийн бодлого, холбогдох стандарт, хууль тогтоомжтой нийцсэн байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургууль нь санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаанд “Санхүүгийн тооцоолох групп” ХХК-ийн “Acolous, payroll” программ хангамж ашигладаг байна.

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн дотоод хяналтын эрсдэлийг төлөвлөлтийн үе шатанд дунд гэж үнэлсэн бөгөөд гүйцэтгэлийн шатанд дахин хянахад дотоод хяналт үр нөлөөтэй гэж үзлээ.

2.6. Төлөвлөлтийн шатанд тодорхойлсон эрсдэл, түүнийг үнэлсэн байдал

Аудитаар Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн бэлтгэсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл нь материаллаг хэмжээний алдаатай илэрхийлэгдээгүй гэсэн үндэслэлтэй нотолгоо олж авахын тулд байгууллагын гадаад дотоод орчин, дотоод хяналтыг судлан, эрсдэлтэй асуудлыг илрүүлж, үнэллээ.

Аудитын төлөвлөлтийн үе шатанд 13 эрсдэлтэй асуудалд горим сорил хэрэгжүүлэхээр төлөвлөж баталгаажуулсан болно.

2.7. Материаллаг байдлын суурь сонгосон үндэслэл, тайлбар

Аудитыг төлөвлөх үе шатны материаллаг байдлыг АДБОУС 1320, АОУС 320-ын дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2019 оны 4 дугаар улирлын Санхүүгийн үр дүнгийн тайланг сонгож, эрсдэлийн түвшин “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын хувь хэмжээг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд сонгосон суурь үзүүлэлтийн дүн 1,608,360.3 мянган төгрөгөөс тооцон 16,083.6 мянган төгрөгөөр материаллаг байдлыг тодорхойлж, баталгаажуулсан.

Гүйцэтгэлийн үе шатанд материаллаг байдлын түвшинг 16,083.6 мянган төгрөгөөр тооцсон нь эрсдэлийн түвшин “дунд” үзсэнтэй холбоотой болно.

2.8. Санхүүгийн тайлангийн үзүүлэлтүүд

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайланд нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 82,0011,2 мянган төгрөгөөр буюу 9,6 хувиар буурсан байна. Өмнөх оны үзүүлэлтээс материаллаг өөрчлөлт гарсан үндсэн хөрөнгийн данс байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага	9,203.1	0	-9,203.1
Урьдчилгаа			
Бараа материал	100,721.3	115,174.6	14,453.3
Үндсэн хөрөнгө	2,170,797.0	2,083,535.6	-87,261.4
Нийт хөрөнгө	2,280,721.4	2,198,710.2	-82,011.2
Өр төлбөр			
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	2,280,721.4	2,198,710.2	-82,011.2
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	2,280,721.4	2,198,710.2	-82,011.2

Авлага дансны үлдэгдэл буурсан нь 2017, 2018 онуудад үүссэн авлагыг бүрэн барагдуулсантай холбоотой байна.

Бараа материалын дансны үлдэгдэл өссөн нь төлбөртэй сурах бичгийг бусад хангамжийн материал дансанд бүртгэснээс шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл буурсан нь элэгдлийн зардлаас шалтгаалжээ. Үндсэн хөрөнгө дансанд хөрөнгө оруулалтаар 66,114.3 мянган төгрөг, хандиваар болон үнэ төлбөргүй хүлээн авсан мянган төгрөгийн 24,279.2 хөрөнгөөр нэмэгдсэн байна.

2.9. Төсвийн гүйцэтгэлийн талаарх тайлбар, тодруулга

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн шууд захирагч нь энэ хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

Тайлант онд Төсвийн шууд захирагчийн хэрэгжүүлэх Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 1 хөтөлбөрт зориулан 1,481,434.4 мянган төгрөгийн төсөв батлагдсанаас 1,481,434.4 мянган төгрөгийг урсгал зардалд зарцуулахаар батлагджээ.

Нийт зардлын 1,179,703.6 мянган төгрөгийг улсын төсвөөс, 301,730.8 мянган төгрөгийг орон нутгийн төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлыг зүйл тус бүрээр харуулсан мэдээллийг энэ тайлангийн 4.5-д харуулав.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 1,448,270.8 мянган төгрөг буюу 97.8 хувьтай байгаа нь цалин хөлс нэмэгдэл урамшууллын зардлаас 1,233.6 мянга, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлаас 33,159.1 мянган төгрөгийн хэмнэлт тус тус гарснаас шалтгаалсан байна.

Нэмэлт төсөв: Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 4,275.1 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ. Үүнээс Нормативд зардалд 500.0 мянга, Эд хогшил худалдан авах зардалд 100.0 мянга, Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр хураамж 2,137.6 мянга, Бараа үйлчилгээний бусад зардалд 1,478.4 мянга, Бусад урсгал шилжүүлэг зардалд 59,1 мянга нийт 4,275.1 мянган төгрөгийг зарцуулсан байна.

2.10. Аудитаар хэрэгжүүлсэн горим сорил, түүний үр дүн

Аудитыг төлөвлөх үе шатанд тогтоосон 13 горим сорил хэрэгжүүллээ.

Аудитаар нийт 346,824.0 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс, 45,000.0 мянган төгрөгийн алдааг залруулж, 301,824.0 мянган төгрөгийн алдаа зөрчлийг арилгах, давтан гаргахгүй байх 2 зөвлөмж өгч байна.

Аудитаар илэрсэн 301,824.0 мянган төгрөгийн алдаа, зөрчилд 2 зөвлөмж өгч, менежментийн захидалд тусгалаа.

2.11. Дараагийн аудитаар авч үзэх буюу анхаарал татахуйц бусад чухал асуудал

Анхаарал татахуйц асуудал байхгүй байна.

2.12. Шилэн дансны мэдээлэл

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургууль нь шилэн дансны нэгдсэн www.shilendans.gov.mn цахим хуудсанд Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйлд зааснаар 149 мэдээлэл байршуулахаас 147 мэдээллийг хугацаанд нь, 2 мэдээллийг хугацаа хоцроож байршуулсан байна.

2.13. Өмнөх аудитаар өгсөн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар 7,074.8 мянган төгрөгийн зөрчлийг арилгах 4 албан шаардлага хүргүүлснээс 7,074,8 мянган төгрөгийн 4 албан шаардлагыг хэрэгжүүлсэн байна.

Нийт 3 зөвлөмж өгснөөс 3 зөвлөмжийг хэрэгжүүлж зөвлөмжийн хэрэгжилт 100 хувьтай байна.

2.14. Дүгнэлтийн хэлбэр, үндэслэл

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийн тайланд аудит хийж, баталгаажуулах ажлыг АДБОУС-ын дагуу, Монгол Улсын холбогдох хууль тогтоомжид нийцүүлэн гүйцэтгэсэн.

“Зөрчилгүй” дүгнэлт

Бид Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, өмчийн өөрчлөлт болон бусад илчлэл тодруулгыг холбогдох хууль, УСНББОУС-ын дагуу материаллаг байдлын хувьд үнэн зөв, бодитой илэрхийлсэн эсэхийг Аудитын гэрчилгээнд тодорхой дурдав.

3. Менежментийн захидал

Төрийн аудитын байгууллага санхүүгийн тайлангийн аудит бүрийн төгсгөлд аудитаар илрүүлсэн зүйлсийг нэгтгэсэн менежментийн захидлыг үйлчлүүлэгч, түүний удирдлагад зориулж бэлтгэдэг бөгөөд түүнд санхүү, нягтлан бодох бүртгэл, тайлагналын бодлого, үйл ажиллагаа, дотоод хяналтыг сайжруулах зөвлөмжийг тусгадаг.

Энэхүү менежментийн захидлын агуулга аудитын үр дүн, дүгнэлтээс урган гарсан болно. Санхүүгийн тайлан, бусад илчлэл тодруулгын талаар санал дүгнэлт гаргахад бидний бодлого, горим зориулагдсан.

Энэ нь нягтлан бодох бүртгэлийн бодлого, горимыг зөвхөн аудитыг үр нөлөөтэй гүйцэтгэхэд шаардагдах цар хүрээнд дахин хянасан бөгөөд оршиж буй бүх сул талыг гаргаж ирэх боломжгүй юм.

Тиймээс аудитын тайланд тусгасан зөвлөмж нь аудит хийх үеийн нөхцөл байдлын талаарх бидний үнэлэлт, дүгнэлтийг илэрхийлж байгаа болно.

Харин эдгээр зөвлөмжийг та бидний хамтын ажиллагааны байр сууринаас гаргасан бөгөөд аудитаар өгсөн зөвлөмжийг хүлээн авч, хэрэгжүүлэх нь танай үүрэг хариуцлага юм.

Менежментийн захидалд дурдсан цаашид санхүүгийн тайланд шууд бөгөөд материаллаг хэмжээгээр нөлөөлж болзошгүй тул анхаарвал зохих асуудлыг тэргүүлэх ач холбогдлоор нь эрэмбэлэн үзүүлэв. Үүнд:

3.1. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.1.1. Илрүүлэлт:

Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж байгаа элэгдлээрээ анхны өртгөө нөхсөн 212,624.0 мянган төгрөгийн хөрөнгө байна.

Энэ нь Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газрын 2019 оны 271 дүгээр тогтоолоор “Хөрөнгийн ашиглалтын хугацаа болон үнийг шинэчлэн тогтоох” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх”, “Үнэлгээ ба хуваарилалт” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.1.2. Эрсдэл:

Санхүүгийн тайлан үнэн бодитой илэрхийлэгдэхгүй байх, хөрөнгийн ашиглалт алдагдах.

3.1.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг давтан гаргахгүй байх, хөрөнгийн ашиглагдах жил, үнийг шинэчлэн тогтоох.

3.1.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

3.2. Байгууллагын үндсэн болон туслах үйл ажиллагаатай холбоотой асуудал

3.2.1. Илрүүлэлт:

Харилцагч байгууллагуудтай 89,200.0 мянган төгрөгийн авлага, өр төлбөрийн үлдэгдлийн баталгааг хийгээгүй байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 19 дүгээр зүйлийн 19.1.4 “Эд хөрөнгийн тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан

авагчтай тогтоосон хугацаанд тооцоо нийлж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах” гэсэн заалттай нийцэхгүй, “Оршин байх” батламж мэдэгдлийг хангахгүй байна.

3.2.2. Эрсдэл:

Харилцагч байгууллагууд авлага, өр төлбөрөө хүлээн зөвшөөрөхгүй байх.

3.2.3. Өгсөн зөвлөмж:

Дээрх зөрчлийг гаргахгүй байх, харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн үлдэгдлийн баталгаа хийж байх.

3.2.4. Байгууллагаас өгсөн хариу тайлбар:

Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн эрхлэгч, нягтлан бодогч нар алдаа зөрчлийг хүлээн зөвшөөрсөн.

Дээрх зөвлөмжийн биелэлтийг төрийн аудитын байгууллагад 2020 оны 6 дугаар сарын 01-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

4. Аудит хийсэн санхүүгийн тайлан

4.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>109,924,382.77</u>	<u>115,174,600.84</u>
33	АВЛАГА	9,203,084.93	00.00
33100	Ажиллагчидтай холбогдсон авлага	2,128,202.00	00.00
335	Бусад авлага	7,074,882.93	00.00
3351	Байгууллагаас авах авлага	7,074,882.93	00.00
35	БАРАА МАТЕРИАЛ	100,721,297.84	115,174,600.84
351	Түүхий эд материал	00.00	47,900.00
35130	Эм боох материал	00.00	47,900.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	1,000,000.00	1,000,000.00
354	Хангамжийн материал	99,721,297.84	114,126,700.84
35410	Бичиг хэргийн материал	1,845,550.00	1,701,100.00
35420	Аж ахуйн материал	37,523,811.94	37,155,830.94
35470	Бусад хангамжийн материал	60,351,935.90	75,269,769.90
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>2,170,796,980.08</u>	<u>2,083,535,571.38</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	2,170,796,980.08	2,083,535,571.38
392	Биет хөрөнгө	1,966,607,480.24	1,879,464,821.62
39201	Барилга, байгууламж, орон сууц	1,654,335,566.00	1,669,362,566.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-71,328,706.20
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	284,042,019.40	297,812,069.40
39206	Хуримтлагдсан элэгдэл	-206,340,529.89	-245,987,170.03
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	179,738,223.35	198,591,487.35
39208	Хуримтлагдсан элэгдэл	-93,774,719.36	-113,164,247.96
39209	Зам, гүүрийн байгууламж	94,984,563.06	94,984,563.06
39210	Хуримтлагдсан элэгдэл	00.00	-22,892,044.68
39217	Ном	53,622,357.68	72,086,304.68
393	Биет бус хөрөнгө	204,189,499.84	204,070,749.76
39301	Програм хангамж	1,350,000.00	1,350,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-1,112,500.16	-1,231,250.24
39303	Бусад биет бус хөрөнгө	203,952,000.00	203,952,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>2,280,721,362.85</u>	<u>2,198,710,172.22</u>
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>2,280,721,362.85</u>	<u>2,198,710,172.22</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	2,280,721,362.85	2,198,710,172.22
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	2,498,640,057.09	2,498,640,057.09
51101	Өмч: - төрийн	2,498,640,057.09	2,498,640,057.09
512	Хуримтлагдсан үр дүн	-841,674,534.04	-923,685,724.67
51210	Өмнөх үеийн үр дүн	-841,674,534.04	-841,674,534.04
51220	Тайлант үеийн үр дүн	00.00	-82,011,190.63
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	623,755,839.80	623,755,839.80
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>2,280,721,362.85</u>	<u>2,198,710,172.22</u>

4.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	1,252,754,552.48	1,526,349,071.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	42,022,952.48	40,639,571.00
120	Нийтлэг татварын бус орлого	42,022,952.48	40,639,571.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	42,022,952.48	40,639,571.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,290,743.00	00.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	38,732,209.48	40,639,571.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	13,247,500.00	306,005,900.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,197,484,100.00	1,179,703,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,247,500.00	4,275,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,247,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,275,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	301,730,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	301,730,800.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,313,175,312.17	1,608,360,261.63
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,313,175,312.17	1,608,360,261.63
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,202,871,692.07	1,516,993,689.10
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	685,501,213.85	938,780,652.29
210101	Үндсэн цалин	485,508,329.85	593,527,281.38
210102	Нэмэгдэл	149,329,471.00	265,042,602.91
210104	Урамшуулал	50,663,413.00	80,210,768.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	141,770,140.98	126,795,608.94
210201	Тэтгэврийн даатгал	131,472,046.98	88,727,608.94
210202	Тэтгэмжийн даатгал	3,374,123.00	7,613,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	2,683,879.00	9,517,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	496,945.00	1,903,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	3,743,147.00	19,034,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	211,963,667.00	250,071,686.27
210301	Гэрэл, цахилгаан	8,183,626.00	7,011,927.27
210302	Түлш, халаалт	183,218,374.00	223,613,647.00
210303	Цэвэр, бохир ус	20,561,667.00	19,446,112.00
2104	Хангамж, бараа материалын зардал	3,025,748.10	6,827,571.90
210401	Бичиг хэрэг	305,840.00	878,998.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	918,597.00	1,141,403.00
210404	Ном, хэвлэл	00.00	125,200.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	282,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,419,311.10	3,599,970.90
2105	Нормативт зардал	800,000.00	2,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	2,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	1,735,461.00	3,568,470.00

210604	Урсгал засвар	1,735,461.00	3,568,470.00
2107	Томилолт, зочны зардал	738,800.00	5,767,300.00
210702	Дотоод албан томилолт	738,800.00	5,767,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,827,249.00	8,485,573.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,827,249.00	8,485,573.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	154,509,412.14	174,596,826.70
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	979,262.00	6,108,969.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	12,040,602.00	15,112,188.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	141,489,548.14	153,375,669.70
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,303,620.10	91,366,572.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,065,750.00	53,103,692.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,275,650.00	51,844,580.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,851,900.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,938,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,259,112.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	237,870.10	5,099,236.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	237,870.10	5,099,236.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	33,163,643.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	33,163,643.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	-60,420,759.69	-82,011,190.63
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	789,726,366.93	00.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	16,786,874.48	00.00
225007	Хөрөнгийн дахин үнэлгээний зардал	772,939,492.45	00.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	-789,726,366.93	00.00
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	-850,147,126.62	-82,011,190.63

4.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	1,214,022,343.00	1,485,709,500.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	3,290,743.00	00.00
120	Нийтлэг татварын бус орлого	3,290,743.00	00.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	3,290,743.00	00.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	3,290,743.00	00.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	1,210,731,600.00	1,485,709,500.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,197,484,100.00	1,179,703,600.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	13,247,500.00	4,275,100.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	13,247,500.00	00.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	00.00	4,275,100.00
1320	Орон нутгийн төсвөөс санхүүжих	00.00	301,730,800.00
132001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/	00.00	301,730,800.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	1,189,265,730.52	1,443,874,450.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,189,265,730.52	1,443,874,450.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,078,962,110.42	1,352,507,877.47
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	705,169,350.00	937,892,044.20
210101	Үндсэн цалин	459,745,450.00	587,429,413.29
210102	Нэмэгдэл	176,924,200.00	271,341,890.91
210104	Урамшуулал	68,499,700.00	79,120,740.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	133,193,700.00	118,962,400.00
210201	Тэтгэврийн даатгал	127,673,700.00	80,894,400.00
210202	Тэтгэмжийн даатгал	2,165,200.00	7,613,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,732,100.00	9,517,000.00
210204	Ажилгүйдлийн даатгал	433,000.00	1,903,500.00
210205	Эрүүл мэндийн даатгал	1,189,700.00	19,034,000.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	210,056,321.00	250,071,686.27
210301	Гэрэл, цахилгаан	8,183,626.00	7,011,927.27
210302	Түлш, халаалт	179,872,695.00	223,613,647.00
210303	Цэвэр, бохир ус	22,000,000.00	19,446,112.00
2104	Хангамж, бараа материалын зардал	4,511,050.00	4,600,600.00
210401	Бичиг хэрэг	799,350.00	800,000.00
210402	Тээвэр, шатахуун	100,000.00	800,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,030,000.00	1,030,000.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	135,000.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	282,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,799,700.00	1,553,600.00
2105	Нормативт зардал	800,000.00	2,100,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	800,000.00	2,100,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	3,216,387.52	3,568,470.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	1,500,000.00	00.00

210604	Урсгал засвар	1,716,387.52	3,568,470.00
2107	Томилолт, зочны зардал	738,800.00	5,767,300.00
210702	Дотоод албан томилолт	738,800.00	5,767,300.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,415,354.00	8,314,550.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	2,415,354.00	8,314,550.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	18,861,147.90	21,230,827.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,410,000.00	6,228,438.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	15,451,147.90	15,002,389.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	110,303,620.10	91,366,572.53
2132	Бусад урсгал шилжүүлэг	110,065,750.00	53,103,692.00
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	50,275,650.00	51,844,580.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	46,851,900.00	00.00
213208	Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг	12,938,200.00	00.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	00.00	1,259,112.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	237,870.10	5,099,236.80
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	237,870.10	5,099,236.80
2134	Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт	00.00	33,163,643.73
213403	Төвлөрүүлэх шилжүүлэг	00.00	33,163,643.73
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	24,756,612.48	41,835,050.00
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	24,756,612.48	41,835,050.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	24,756,612.48	41,835,050.00
2200	Дотоод эх үүсвэрээр	24,756,612.48	41,835,050.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	24,756,612.48	41,835,050.00
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-24,756,612.48	-41,835,050.00
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	00.00	00.00
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	00.00	00.00
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	00.00	00.00

4.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2017 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,294,688,057.09	00.00	-18,536,395.82	2,276,151,661.27
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	-338,587.26	-338,587.26
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,294,688,057.09	00.00	-18,874,983.08	2,275,813,074.01
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	00.00	00.00	00.00	00.00
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	00.00	00.00	00.00	00.00
C07	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	406,918,037.75	406,918,037.75
C08	2018 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	-841,674,534.04	2,280,721,362.85
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	00.00	00.00	00.00	00.00
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	-841,674,534.04	2,280,721,362.85
D08	Тайлант үеийн үр дүн	00.00	00.00	-82,011,190.63	-82,011,190.63
D09	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	2,498,640,057.09	623,755,839.80	-923,685,724.67	2,198,710,172.22

4.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан

/төгрөг/

Эдийн засгийн ангилал	Үзүүлэлт	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Хувь
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	1,481,434,400.00	1,448,270,756.27	33,163,643.73	97.76
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,481,434,400.00	1,448,270,756.27	33,163,643.73	97.76
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,424,992,700.00	1,390,126,939.47	34,865,760.53	97.55
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	939,125,500.00	937,892,044.20	1,233,455.80	99.87
210101	Үндсэн цалин	581,957,800.00	587,429,413.29	(5,471,613.29)	100.94
210102	Нэмэгдэл	277,695,600.00	271,341,890.91	6,353,709.09	97.71
210104	Урамшуулал	79,472,100.00	79,120,740.00	351,360.00	99.56
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	118,962,400.00	118,962,400.00	-	100.00
210201	Тэтгэврийн даатгал	80,894,400.00	80,894,400.00	-	100.00
210202	Тэтгэмжийн даатгал	7,613,500.00	7,613,500.00	-	100.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	9,517,000.00	9,517,000.00	-	100.00
210204	Ажилгүйдлийн даатгал	1,903,500.00	1,903,500.00	-	100.00
210205	Эрүүл мэндийн даатгал	19,034,000.00	19,034,000.00	-	100.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	283,230,800.00	250,071,686.27	33,159,113.73	88.29
210301	Гэрэл, цахилгаан	29,620,000.00	7,011,927.27	22,608,072.73	23.67
210302	Түлш, халаалт	228,251,500.00	223,613,647.00	4,637,853.00	97.97
210303	Цэвэр, бохир ус	25,359,300.00	19,446,112.00	5,913,188.00	76.68
2104	Хангамж, бараа материалын зардал	4,912,000.00	4,911,600.00	400.00	99.99
210401	Бичиг хэрэг	800,000.00	800,000.00	-	100.00
210402	Тээвэр, шатахуун	800,000.00	800,000.00	-	100.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,030,000.00	1,030,000.00	-	100.00
210404	Ном, хэвлэл	500,000.00	446,000.00	54,000.00	89.20
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	282,000.00	282,000.00	-	100.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,500,000.00	1,553,600.00	(53,600.00)	103.57
2105	Нормативт зардал	1,600,000.00	1,600,000.00	-	100.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	1,600,000.00	1,600,000.00	-	100.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	33,630,000.00	33,546,470.00	83,530.00	99.75
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,250,000.00	5,247,000.00	3,000.00	99.94
210602	Тавилга	9,880,000.00	9,804,000.00	76,000.00	99.23
210604	Урсгал засвар	18,500,000.00	18,495,470.00	4,530.00	99.98
2107	Томилолт, зочны зардал	5,862,000.00	5,767,300.00	94,700.00	98.38
210702	Дотоод албан томилолт	5,862,000.00	5,767,300.00	94,700.00	98.38
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,100,000.00	9,100,000.00	-	100.00

210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	9,100,000.00	9,100,000.00	-	100.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	28570000.00	27275439.00	1,294,561.00	95.47
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	4,750,000.00	4,750,000.00	-	100.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	23,820,000.00	23,525,439.00	294,561.00	98.76
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	56441700.00	58143816.80	(1,702,116.80)	103.02
2132	Бусад урсгал шилжүүлэг	56,441,700.00	53,044,580.00	3,397,120.00	93.98
213205	Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал	55,241,700.00	51,844,580.00	3,397,120.00	93.85
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,200,000.00	1,200,000.00	-	100.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	1,481,434,400.00	1,481,434,400.00	-	100.00
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	1,179,703,600.00	1,179,703,600.00	-	100.00
131007	Тусгай зориулалтын шилжүүлгээс санхүүжих	1,179,703,600.00	1,179,703,600.00	-	100.00
1320	ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	301,730,800.00	301,730,800.00	-	100.00
132001	Орон нутгийн төсвөөс	301,730,800.00	301,730,800.00	-	100.00
62	АЖИЛЛАГСАДЫН ТОО	83	83	-	100.00
620001	Удирдах ажилтан	1	1	-	100.00
620002	Гүйцэтгэх ажилтан	57	57	-	100.00
620003	Үйлчлэх ажилтан	25	25	-	100.00

4.5 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Тайлант хугацаа: 2019 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон тайлан /төгрөг/

ҮЗҮҮЛЭЛТ	ТӨЛӨВЛӨГӨӨ	ГҮЙЦЭТГЭЛ
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
I. НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	4,275,100.00	4,275,100.00
УРСГАЛ ЗАРДЛЫН ДҮН	4,275,100.00	4,275,100.00
Бараа, үйлчилгээний зардал	4,215,988.00	4,215,988.00
Нормативт зардал	500,000.00	500,000.00
Нормын хувцас зөөлөн эдлэл	500,000.00	500,000.00
Эд хогшил худалдан авах	100,000.00	100,000.00
Урсгал засвар	100,000.00	100,000.00
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр	2,137,550	2,137,550
Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	2,137,550	2,137,550
Бараа үйлчилгээний бусад зардал	1,478,438.00	1,478,438.00
Бараа үйлчилгээний бусад зардал	1,478,438.00	1,478,438.00
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	59,112.00	59,112.00
Бусад урсгал шилжүүлэг	59,112.00	59,112.00
Нэг удаагийн тэтгэмж урамшуулал	59,112.00	59,112.00
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	4,275,100.00	4,275,100.00
Нэмэлт санхүүжилтийн орлого	4,275,100.00	4,275,100.00
Төсвийн байгууллагын үндсэн үйл ажилагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	4,275,100.00	4,275,100.00
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0	0
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0	0
ТӨСВИЙН БУСАД МЭДЭЭЛЛИЙН АНГИЛАЛ	0	0
БАЙГУУЛЛАГЫН ТОО	0	0
АЖИЛЛАГСДЫН ТОО	78	78
Удирдах ажилтан	1	1
Гүйцэтгэх ажилтан	53	53
Үйлчлэх ажилтан	24	24

5. Аудитын явцад илэрсэн алдаа, зөрчлийн жагсаалт

Огноо: 2020.02.25	Аудитын нэр: Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургуулийн 2019 оны жилийн эцсийн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн аудит	Аудитын код: ДГА-2020/67/СТА-ТШЗ
Шалгагдсан байгууллагын нэр: Дорноговь аймгийн Сайншанд сумын 5 дугаар сургууль		Мянган төгрөгөөр

№	Алдаа, зөрчлийн товч утга	Мөнгөн дүн	Аудитын байгууллагаас гаргасан шийдэл	Алдаа, зөрчилтэй асуудал гаргасан албан тушаалтны	
			Нэр	Албан тушаал	Овог нэр
	1	2	3	4	5
1	Байгууллагын үйл ажиллагаанд ашиглагдаж элэгдлээрээ өртгөө нөхсөн байна байгаа анхны хөрөнгө	212,624.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Эрдэнэхүү
2	Харилцагч байгууллагуудтай авлага, өр төлбөрийн үлдэгдлийн баталгааг хийгээгүй байна	89,200.0	Зөвлөмж	Нягтлан бодогч	Б.Эрдэнэхүү